

**ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧИЙН
2018 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД
ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ**

Агуулга

| | | |
|-------|---|----|
| 1 | Аудитын гэрчилгээ | 3 |
| 2 | Аудитын тайлан | 5 |
| 2.1 | Оршил | 5 |
| 2.2 | Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага | 5 |
| 2.3 | Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт | 6 |
| 2.4 | Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин | 6 |
| 2.5 | Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ | 7 |
| 2.6 | Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал | 7 |
| 2.7 | Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар | 8 |
| 2.8 | Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн | 8 |
| 2.8.1 | Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал | 9 |
| 2.9 | Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал | 9 |
| 2.10 | Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга | 10 |
| 2.11 | Шилэн дансны мэдээлэл | 10 |
| 2.12 | Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга | 10 |
| 2.13 | Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл | 10 |
| 3 | Менежментийн захидал | 12 |
| 4 | Аудит хийсэн санхүүгийн тайлан | 16 |

Товчилсон үгийн жагсаалт

| | |
|----------|---|
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт |
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагуудын Олон Улсын Стандарт |
| АОУС | Аудитын Олон Улсын Стандарт |



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг
Бага тойруу-3, Засгийн газрын IV байр
Утас:26-04-37, Факс:62-26-32-30
E-mail: info@audit.gov.mn

УУЛ УУРХАЙ, ХҮНД ҮЙЛДВЭРИЙН
ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН
ДАРГА Г.НАНДИНЖАРГАЛ ТАНАА

2019.02.25 № 06/329
танай _____-ны № _____-т

Аудитын гэрчилгээ

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Хязгаарлалттай санал дүгнэлт

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга, илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагад мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, програм хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.

Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Аудитын гол асуудал

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны санхүүгийн тайлангийн аудитаар санхүүгийн тайланг хуулийн хугацаанд ирүүлээгүй бөгөөд өглөг, авлагын зарим гүйлгээнд дэлгэрэнгүй журнал хөтлөөгүй, авлага, өр төлбөр үүсгэсэн, батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан, урьдчилж гарсан зардал, бараа материалыг шууд зардлаар бүртгэсэн зэрэг нийт 232,747.3 мянган төгрөгийн зөрчил илэрсэн нь бидний тооцсон материаллаг байдлын түвшингээс давж, санхүүгийн тайлангийн “Үнэн зөв байдал”, “Үнэлгээ”, “Хэмжилт”, “Иж бүрэн байх” гэсэн батламж мэдэгдлүүдийг тус тус хангахгүй байна.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1–д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

САНХҮҮГИЙН АУДИТЫН
ГАЗРЫН ЗАХИРАЛ БӨГӨӨД
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.НАРАНЧИМЭГ

2 Аудитын тайлан

2.1. Оршил

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг тус яамны Төрийн нарийн бичгийн дарга Г.Нандинжаргал Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчлийн талаарх тайлбар, тодруулга зэрэг аудитын үр дүнгийн талаарх тайлбар, тодруулга, аудитын санал дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, тайлагнал, дотоод хяналтын системийг боловсронгуй болгох зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

Дараагийн заалтад аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг батлагдсан ангилал, үзүүлэлтээр бэлтгэж оруулав.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд санал дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2019 оны 01 дүгээр сарын 25-наас 02 дугаар сарын 01-ний өдрийн хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 02 дугаар сарын 11-ний өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн Санхүүгийн аудитын газрын аудитор Б.Эрдэнэзул хариуцаж хэрэгжүүлэв.

Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яам 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг 2019 оны 01 дүгээр сарын 28-ны өдөр Санхүүгийн аудитын газарт ирүүлсэн бөгөөд тус газрын 03/259 дугаар бүхий албан бичгээр ирүүлсэн.

2.3. Аудитын явцад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

Аудитын явцад АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан төрийн аудитын байгууллагын санхүүгийн тайлангийн аудитын талаарх бодлого, арга зүйг мөрдөж ажиллав.

Дээрх стандарт, зарчимд нийцүүлж Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, түүнд тусгасан үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

Аудитын үйл явц, үр дүнг АДБОУС, АОУС-ын дагуу шат шатны чанарын хяналт хийж баталгаажуулсан болно.

Аудитыг дээрх бодлого, арга зүйд нийцүүлэн төлөвлөлтийн шатанд баталсан аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу явуулав.

Аудит хийхэд Нягтлан бодох бүртгэлийн нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчмууд, УСНББОУС, Төсвийн тухай хууль болон Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийг гол шалгуур болголоо.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Бид аудитын төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу байгууллагын үйл ажиллагаа, түүний гадаад дотоод орчны талаар шаардлагатай хэмжээнд судалж, тэдгээрийн үр дүнг аудитад ашигласан.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны талаарх ерөнхий мэдээллийг аудитыг төлөвлөх үе шатанд шинэчлэн баримтжуулж, А101 маягаар баталгаажуулсан болно.

Эрхэм зорилго:

Монгол Улсын Засгийн газрын 2016 оны 81 дүгээр тогтоолын 5 дугаар хавсралтаар “Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яамны стратеги, бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр” баталсныг 2018 оны 12 дугаар 05-ны өдрийн 370 дугаар тогтоолоор шинэчлэн баталж, мөрдөж байна.

Уг баримт бичигт эрхэм зорилгоо “Ил тод, хариуцлагатай уул уурхай, хүнд үйлдвэрлэлийг хөгжүүлэх, эрдэс баялгийн сан хөмрөгийг арвижуулах замаар тогтвортой, олон тулгуурт эдийн засгийн бүтцийг бий болгоход оршино” гэж тодорхойлон, үйл ажиллагааны 9 тэргүүлэх чиглэлийг баталсан байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны үндсэн болон үндсэн бус үйл ажиллагааны талаар төлөвлөлтийн шатанд судалж, баримтжуулсан.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны удирдлага төсвийн шууд захирагчийн хувьд дараах хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын Нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын хүрээнд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагааг эрхлэн гүйцэтгэж байна. Үүнд:

- Төсвийн тухай хууль
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль
- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль

- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль
- Шилэн дансны тухай хууль
- Монгол Улсын 2018 оны Төсвийн тухай хууль

Тайлант хугацаанд дээрх бодлого, журамд томоохон шинэчлэлт, өөрчлөлт гарсан эсэх талаар дараах заалтад тэмдэглэв.

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, үйл ажиллагаа болон дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан. Энэ нь материаллаг алдаа гарахаас хамгаалах ёстой гол бодлого, хяналтуудыг тодруулах, судлах зорилготой юм.

Тус газар нь санхүүгийн үйл ажиллагаандаа мөрдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг “Нягтлан бодох бүртгэлийг хөгжүүлэх сан”-аар гэрээгээр гүйцэтгүүлэн, батлуулсан байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд ашиглаж байгаа мэдээллийн технологи, бүртгэл мэдээллийн системийн үйл ажиллагаатай танилцан түүний нарийн төвөгтэй байдлыг үнэлэхэд мэдээллийн технологийн мэргэжилтнийг аудитад татан оролцуулах шаардлагагүй гэж үзсэн тул аудитыг томилогдсон баг гүйцэтгэлээ.

Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яам санхүүгийн тайланг бэлтгэхдээ нягтлан бодох бүртгэлийн “Acolous” програм хангамж ашигладаг байна.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд “Дунд” гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт “Үр нөлөөгүй” гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитын явцад Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судалж, санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлантай холбоотой эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэлсэн.

Аудитыг төлөвлөх үе шатанд эрсдэлийн үнэлгээний урьдчилсан горим хэрэгжүүлэн 7 эрсдэлтэй асуудал тодорхойлж, эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн 7 асуудалд нарийвчилсан горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

Аудитын чиглэл тус бүрд хамаарах илрүүлсэн эрсдэлийн жагсаалт, түүний үнэлгээг Б301 маягтаар, эрсдэлтэй асуудлыг сорих аудитын горим, сорил, түүнийг баримтжуулах, нотлох зүйлс цуглуулах арга зүйг Б401, Б402 маягтаар тус тус баримтжуулав.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх болон гүйцэтгэх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон. Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлын суурь үзүүлэлтийг эхний хагас жилийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар тооцсон бөгөөд гүйцэтгэлийн үе шатанд жилийн эцсийн санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлын 1 хувиар буюу 28,614.4 мянган төгрөгөөр тодорхойлж, баталгаажууллаа.

Тус байгууллагын нийт хөрөнгө, цэвэр өмчийн дүн бага, эх үүсвэр зөвхөн улсын төсвийн санхүүжилтээс бүрддэг тул материаллаг байдлын суурийг нийт зардлаар тооцож, төлөвлөлтийн үе шатанд эрсдэлийг “Дунд” гэж үнэлсэн тул материаллаг байдлын хувь хэмжээг 1-ээр тооцсон болно.

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлын түвшинг В201, аудитыг гүйцэтгэх үе шатны материаллаг байдлын түвшинг В401 маягтаар тус тус баримтжуулан баталгаажуулав.

2.8. Аудитын явцад хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон эрсдэл тус бүрд хэрэгжүүлэхээр төлөвлөсөн горим сорилын хэрэгжилт, гол үр дүнгийн талаар дор нэгтгэн тэмдэглэв.

Эрсдэлийн үнэлгээний дүнд үндэслэн аудитын 3 чиглэлээр аудитын 6 горим сорил гүйцэтгэж, үнэлэхэд 17 асуудлыг алдаа, зөрчилтэйд тооцож, 3 асуудлыг алдаа, зөрчилд тооцохгүй гэж шийдвэрлэснээс гадна 5 асуудлыг аудитын явцад санхүүгийн тайланд залруулга хийлгэлээ.

Аудитын явцад хийсэн залруулгын талаарх мэдээллийг В30103 маягтаар нэгтгэж, баримтжуулсан болно.

Аудитын явцад илрүүлсэн залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг В501 маягтаар нэгтгэж, баримтжуулсан бөгөөд байгууллагын удирдлага болон холбогдох албан тушаалтнуудад танилцуулж, баталгаажуулсан.

Дээрх залруулаагүй алдаа, зөрчилтэй асуудлыг дараах байдлаар ангилав.

Залруулаагүй алдаа, зөрчилтэй
асуудлыг ангилсан байдал

(Мянган төгрөгөөр)

| № | Шийдэл | Тоо | Дүн | Тайлбар |
|---|-----------------------|-----|-----------|---------|
| 1 | Зөвлөмж өгсөн | 7 | 634,922.5 | |
| 3 | Албан шаардлага өгсөн | 2 | 55,297.3 | |
| | Дүн | 9 | 690,219.8 | |

2.8.1. Зөвлөмж өгөхөөс бусад хэлбэрээр шийдвэрлэсэн алдаа, зөрчилтэй асуудал

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчилтэй асуудлаас зөвлөмж өгөх асуудлыг Менежментийн захидалд оруулж, бусад хэлбэрээр шийдсэн алдаа, зөрчилтэй асуудлын дэлгэрэнгүйг дараах заалтад хураангуйлан тэмдэглэв. Үүнд:

- Улс төрийн албан тушаалтанд 6,569.1 мянган төгрөгийн төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл бодож олгосон.
- Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан, зохих зөвшөөрөлгүйгээр зардлын бүлэг хооронд гүйлгэн зарцуулсан, анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан зэрэг нийт 48,728.2 мянган төгрөгийг зарцуулсан.

Шийдвэрлэсэн нь: Дээр дурдсан 55,297.3 мянган төгрөгийн зөрчлийг арилгах, давтан гаргахгүй ажиллах албан шаардлага хүргүүлэв.

2.9. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Аудитын явцад анхаарал татахуйц дараах асуудлууд ажиглагдлаа. Үүнд:

1. Бараа материалын болон зарим сарын кассын тайланг нягтлан бодогчийн зүгээс хянаж баталгаажуулаагүй байгаа нь цаашид санхүүгийн тайланд материаллаг байдлаар нөлөөлөхүйц алдаа, зөрчил үүсэх эрсдэлтэй байна.
2. Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам нь үйл ажиллагааны хүрээнд орлого олдоггүй байхад 52,588.5 мянган төгрөгийн үндсэн үйл ажиллагааны орлого, 802,611.5 мянган төгрөгийн туслах үйл ажиллагааны орлого төлөвлөж, батлуулсан байна. Энэ нь Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 2.1-д "Орлого гэдэг нь тайлангийн хугацаанд байгууллагын ердийн үйл ажиллагааны үр дүнд орж ирж байгаа бөгөөд өмчлөгчдөөс оруулах нэмэгдэл хөрөнгө оруулалтаас бусад цэвэр хөрөнгө/өмчийг нэмэгдүүлэх, эдийн засгийн өгөөж буюу үйлчилгээний чадавхиас орох нийт орлогын урсгал юм" гэж заасантай нийцэхгүй бөгөөд цаашид санхүүгийн тайланд материаллаг байдлаар нөлөөлөх эрсдэлтэй байна.
3. Уул уурхай хүнд үйлдвэрийн яамны Төрийн нарийн бичгийн даргын 2018 оны 04 дүгээр сарын 04-ний өдрийн Б/50 дугаар тушаалаар тус яамны ТЕЗ-ийн нягтлан бодогчоор үйл ажиллагааны ахлах нягтлан бодогчийн албан тушаалыг хавсран гүйцэтгүүлсэн нь санхүүгийн үйл ажиллагаанд тавих дотоод хяналт алдагдах, ажлын хуваарилалт алдагдах, ашиг сонирхлын зөрчил үүсэх эрсдэлтэй байна.
4. Тус яамны санхүүгийн тайланд бүртгэлтэй 583.0 сая төгрөгийн барилга байгууламжийг Засгийн газрын 2018 оны 61 дүгээр тогтоолоор Орхон, Дархан-Уул аймаг, Багануур дүүргийн үйлдвэрлэл, технологийн паркуудад шилжүүлсэн байна.

Аудитын цаг хугацааны хязгаарлагдмал байдлаас шалтгаалан 2018 оны санхүүгийн тайлангийн аудитад хамруулж чадаагүй, дараагийн аудитаар нарийвчлан авч үзэх дараах асуудлууд байна. Үүнд:

1. Худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гүйцэтгэл, хэрэгжилт.
2. Бараа материалын бүртгэл, хөдөлгөөн, ашиглалт, хамгаалалт.

2.10. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудитаар төсвийн шууд захирагч нь батлагдсан төсөв, түүний гүйцэтгэлийг зохих журмын дагуу зохион байгуулсан, үнэн зөв, тайлагнасан эсэхэд үнэлэлт өгөхийг зорьдог.

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны чиг үүргээ хэрэгжүүлэхтэй нь холбоотой 6 хөтөлбөр, арга хэмжээнд зориулан 2018 онд 3,085,193.0 мянган төгрөгийн төсөв батлагджээ. Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийн талаарх дэлгэрэнгүй мэдээллийг энэ тайлангийн 4.5-д дэлгэрэнгүй харуулав.

Тайлант онд төсвийн зардлын нийт гүйцэтгэл 3,084,587.4 мянган төгрөгөөр тайлагнагдаж, 605.6 мянган төгрөг хэмнэгдсэнийг улсын төсөвт татан төвлөрүүлсэн байна.

2.11. Шилэн дансны мэдээлэл

Уул, уурхай, хүнд үйлдвэрийн яам Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан мэдээллийг өөрийн цахим хуудсаар дамжуулан тухай бүр ил тод мэдээлж байх үүрэгтэй.

Тус яам 2018 онд Шилэн дансны нэгдсэн цахим хуудсанд нийт 144 мэдээлэл оруулсан бөгөөд тус яамны дотоод аудитын нэгжээс Шилэн дансны хуулийн хэрэгжилтэд хяналт хийгдээгүй байна.

2.12. Өмнөх зөвлөмжийн хэрэгжилтийн талаарх тайлбар, тодруулга

Өмнөх санхүүгийн тайлангийн аудитаар 4 зөвлөмж өгсөн бөгөөд зөвлөмжийн биелэлт 2018 оны жилийн эцсийн байдлаар 75 хувьтай байна. Дараах зөвлөмж хэрэгжээгүй байна. Үүнд:

- “Нүүрснээс нийлэг хий үйлдвэрлэх төсөл”, “Зэсийн баяжмал боловсруулах үйлдвэр барих төсөл”-ийн нэгжүүдийн санхүүжилтийг Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2017 оны төсөвт тусгасан байна. Тус төслийн нэгжүүдийг хариуцсан захирал, нягтлан бодогч томилогдон ажиллаж байгаа боловч яамны аппаратын нягтлан бодогч гүйлгээг хийж хоёрдугаар гарын үсэг, ТНБДарга нэгдүгээр гарын үсэг зурж байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.6.1-т “төсвийн захирагч нь түүнийг томилсон байгууллага, албан тушаалтны өмнө, эсхүл дээд шатныхаа төсвийн захирагчийн өмнө төсвийн талаар хариуцлага хүлээдэг байх” гэж заасантай нийцэхгүй байна.

Зөвлөмжийн биелэлтийн талаарх мэдээллийг ажлын баримт материалд хадгалсан бөгөөд гүйцэтгэлийг аудитын явцад дахин нягталсан болно.

2.13. Санал дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

Аудитын гол асуудалд дурдсан алдаа, зөрчлийг эс тооцвол Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга, илэрхийлсэн тул хязгаарлалттай санал дүгнэлт гаргаж байна. Хязгаарласан гол асуудлуудыг аудитын гэрчилгээнд тусгасан болно.

Аудитын гэрчилгээг энэ тайлангийн 1 дүгээр хэсэгт үзүүлэв.

3 Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга АДБОУС болон аудитын дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1 Авлага, өр төлбөрийн талаар

3.1.1 Илрүүлэлт:

Авлага, өр төлбөрийн бүртгэл тайлагналтай холбоотой дараах алдаа, зөрчил илэрлээ. Үүнд:

- 70 орчим харилцагчтай үүссэн тооцоог хооронд нь зөрүүлэн хаасан бөгөөд харилцагч байгууллагуудтай тайлант хугацаанд гарсан ажил гүйлгээ, үлдэгдлийг тооцоо нийлж баталгаажуулаагүй.
- Насжилт ихтэй 40,181.0 мянган төгрөгийн авлага үүсгэснийг барагдуулаагүй, барагдуулах тодорхой арга хэмжээ аваагүй.
- Төсвийг зүй зохистой удирдаагүйгээс 6,769.3 мянган төгрөгийн авлага, өр төлбөр үүсгэсэн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.8-д “төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй байх”, 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах”, 16.5.2-т “батлагдсан төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14.3-т “Нягтлан бодох бүртгэлийн мэдээлэл боловсруулах ажиллагааг дараах дарааллаар гүйцэтгэнэ: 14.3.2.журналд бичих; 14.3.3.дэлгэрэнгүй болон ерөнхий данс хөтлөх” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.1.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, төсвийн хөрөнгө үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй зарцуулагдах.

3.1.3 Зөвлөмж:

3.1.2.1 Өглөг, авлагын дэлгэрэнгүй бүртгэлийг холбогдох стандарт, хууль, журмын дагуу хөтлөх.

3.1.2.2 Насжилт ихтэй авлагыг тооцоо нийлэн баталгаажуулж, барагдуулах арга хэмжээ авч хэрэгжүүлэх.

3.1.2.3 Төсвийг зохистой удирдаж авлага, өр төлбөр үүсгэхгүй ажиллах.

3.1.4 Байгууллагаас өгсөн хариу:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.2 Урьдчилж гарсан зардал /төлбөр/-ын талаар

3.2.1 Илрүүлэлт:

Урьдчилан олгосон гадаад албан томилолтын болон хэвлэл мэдээллийн 90,835.7 мянган төгрөгийн ажил гүйлгээг шууд зардлаар бүртгэсэн нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1-д “төсвийн байгууллагын өдөр тутмын үйл ажиллагааг удирдах; 16.5.7-д “байгууллагын санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн мэдээ, тайлан, үр дүнгийн гэрээний биелэлтийг үнэн зөв гаргах, тогтоосон хугацаанд тайлагнах”, Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан Нягтлан бодох бүртгэлийн дансны зааврын 4 дүгээр зүйлийн 4.6-д “Бэлтгэн нийлүүлэгчид бараа бүтээгдэхүүн, үйлчилгээний үнийг урьдчилж төлсөн урьдчилгаа болон урьдчилан төлсөн зардлуудыг урьдчилж төлсөн төлбөр/зардал/ гэнэ” гэж заасантай тус тус байна.

3.2.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, төсвийн хөрөнгө дотоод хяналтгүй, үр ашиггүй зарцуулагдах.

3.2.3 Зөвлөмж:

Урьдчилж гарсан зардлыг 2019 оны 1 дүгээр улирлын санхүүгийн тайланд залруулга хийх.

3.2.4 Байгууллагаас өгсөн хариу:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.3 Зардал

3.3.1 Илрүүлэлт:

Цалин, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэл, дотоод албан томилолт, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний төлбөр хураамжийн нийт 415,057.2 мянган төгрөгийн зардлыг санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд бодит гүйцэтгэлд үндэслэн тайлагнаагүй нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн

41.2.2-т “батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”, 41.2.3-д “төсвийн гүйцэтгэлийг хууль тогтоомжийн дагуу хэрэгжүүлж тайлагнах” гэж заасантай болон Сангийн сайдын 2014 оны 55 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн зарлагын эдийн засгийн ангиллыг ашиглах заавар”-тай тус тус нийцэхгүй байна.

3.3.2 Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн зөв илэрхийлэгдэхгүй байх, хэрэглэгчдэд буруу мэдээлэл хүрэх

3.3.3 Зөвлөмж:

Мөнгөн гүйлгээний тайлангийн зардлын дансдыг бодит гүйцэтгэлд үндэслэн, үнэн зөв тайлагнаж байх.

3.3.4 Байгууллагаас өгсөн хариу:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.4 Бараа материал

3.4.1 Илрүүлэлт:

Зөвлөх үйлчилгээний гэрээний дагуу хийгдсэн 79,844.8 мянган төгрөгийн эрдэм шинжилгээ судалгааны ажлын ном товхимол, тайлан зэргийг шууд зардлаар хүлээн зөвшөөрч бүртгэсэн нь УСНББОУС-12 “Бараа материал”-ын 9(б)-д “Үйлчилгээ үзүүлэхэд хуваарилагдах эсвэл хэрэглэгдэх материал буюу хангамжийн зүйлс хэлбэрээр байгаа хөрөнгө” гэсэн тодорхойлолттой нийцэхгүй байна.

3.4.2 Эрсдэл:

Төсвийн хөрөнгө үр ашиггүй, арвилан хэмнэлтгүй, дотоод хяналтгүй зарцуулагдах.

3.4.3 Зөвлөмж:

Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт тус яамны онцлог болох эрдэм шинжилгээ судалгааны ажлын ном товхимол, тайлан зэргийг хэрхэн бүртгэх талаарх бодлогыг тодорхой тусган, мөрдөж ажиллах.

3.4.4 Байгууллагаас өгсөн хариу:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

3.5 Дотоод хяналт

3.5.1 Илрүүлэлт:

Нийгмийн даатгалын тайланд 2,234.4 мянган төгрөгийн цалин илүү, дутуу тайлагнасан нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.4-т “Аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага, нягтлан бодогч нь үйлдвэрлэл, үйлчилгээний шат дамжлага, аж ахуйн үйл ажиллагааны хүрээнд гарсан хөрөнгө, эх үүсвэрийн хөдлөл, өөрчлөлт бүрийг анхан шатны баримтад бичгээр болон цахимаар бичилт хийж баталгаажуулна”, 20 дугаар зүйлийн 20.2.7-д “аж ахуйн нэгж,

байгууллагын татвар, төлбөр, хураамж, шимтгэлийн тооцооллыг шалгах, тэдгээрт хяналт тавих, мэргэжлийн үйлчилгээний зөвлөгөө туслалцаа авах” гэж заасантай тус тус нийцэхгүй байна.

3.5.2 Эрсдэл:

Ажиллагсдын нийгмийн даатгалын шимтгэл төлөлт буруу тооцогдох, авлага, өр төлбөр үүсэх.

3.5.3 Зөвлөмж:

2019 оны 1 дүгээр улиралд багтаан нийгмийн даатгалын тайланг нөхөн залруулах.

3.5.4 Байгууллагаас өгсөн хариу:

Зөвлөмжийг хэрэгжүүлэн ажиллана.

Зөвлөмжийн биелэлтийг Үндэсний аудитын газарт 2019 оны 7 дугаар сарын 1-ний дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4 Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

СТ-1А

САНХҮҮГИЙН БАЙДЛЫН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|------------|---|-----------------------|-------------------------|
| 1 | ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН | 82,041,012.10 | 505,841,961.93 |
| 33 | АВЛАГА | 40,181,000.00 | 80,081,670.93 |
| 33200 | Төлбөртэй үйлчилгээний авлага | | 792,670.93 |
| 33300 | Татаас, санхүүжилтийн авлага | | 39,108,000.00 |
| 335 | Бусад авлага | 40,181,000.00 | 40,181,000.00 |
| 3351 | Байгууллагаас авах авлага | 40,181,000.00 | 40,181,000.00 |
| 34 | УРЬДЧИЛГАА | - | 384,999,067.00 |
| 34600 | Урьдчилж гарсан зардал | - | 384,999,067.00 |
| 35 | БАРАА МАТЕРИАЛ | 41,860,012.10 | 40,761,224.00 |
| 354 | Хангамжийн материал | 41,860,012.10 | 40,761,224.00 |
| 35410 | Бичиг хэргийн материал | 1,368,900.00 | 930,250.00 |
| 35420 | Аж ахуйн материал | 38,812,112.10 | 39,830,974.00 |
| 35440 | Түлш, шатах тослох материал | 1,679,000.00 | - |
| 2 | ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН | 896,854,207.51 | 504,444,627.66 |
| 39 | ҮНДСЭН ХӨРӨНГӨ | 896,854,207.51 | 504,444,627.66 |
| 392 | Биет хөрөнгө | 873,100,032.51 | 283,601,154.09 |
| 39201 | Барилга, байгууламж, орон сууц | 583,000,000.00 | - |
| 39202 | Хуримтлагдсан элэгдэл | (60,963,889.00) | - |
| 39203 | Авто-тээврийн хэрэгсэл | 579,304,720.00 | 579,304,720.00 |
| 39204 | Хуримтлагдсан элэгдэл | (383,245,125.00) | (479,795,911.68) |
| 39205 | Машин тоног төхөөрөмж (компьютер) | 446,607,883.40 | 490,786,883.40 |
| 39206 | Хуримтлагдсан элэгдэл | (405,620,917.00) | (432,031,197.66) |
| 39207 | Тавилга, аж ахуйн эд хогшил | 315,824,653.11 | 355,773,853.11 |
| 39208 | Хуримтлагдсан элэгдэл | (203,541,793.00) | (232,171,693.08) |
| 39217 | Ном | 1,734,500.00 | 1,734,500.00 |
| 393 | Биет бус хөрөнгө | 23,754,175.00 | 220,843,473.57 |
| 39303 | Бусад биет бус хөрөнгө | 42,969,800.00 | 259,920,148.57 |
| 39304 | Хуримтлагдсан элэгдэл | (19,215,625.00) | (39,076,675.00) |
| 3 | НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II | 978,895,219.61 | 1,010,286,589.59 |
| 4 | НИЙТ ӨР ТӨЛБӨР | - | 45,084,665.37 |
| 41 | БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР | - | 45,084,665.37 |
| 413 | Өглөг | - | 5,976,665.37 |
| 41310 | Ажилчидтай холбогдсон өглөг | - | 5,976,665.37 |
| 414 | Урьдчилж орсон орлого | - | 39,108,000.00 |
| 41410 | Засгийн газрын байгууллага, бусад шатны төсөв | | 39,108,000.00 |
| 5 | ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН | 978,895,219.61 | 965,201,924.22 |
| 51 | Засгийн газрын хувь оролцоо | 978,895,219.61 | 965,201,924.22 |
| 511 | Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 304,117,253.38 | 304,117,253.38 |

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|------------|--|------------------------------|--------------------------------|
| 51101 | Өмч: - төрийн | 304,117,253.38 | 304,117,253.38 |
| 512 | Хуримтлагдсан үр дүн | 674,777,966.23 | 661,084,670.84 |
| 51210 | Өмнөх үеийн үр дүн | 674,777,966.23 | 939,526,423.23 |
| 51220 | Тайлант үеийн үр дүн | | (278,441,752.39) |
| 6 | ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V | <u>978,895,219.61</u> | <u>1,010,286,589.59</u> |

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

СТ-2А

САНХҮҮГИЙН ҮР ДҮНГИЙН ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|--|-------------------------|-------------------------|
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I) | 3,155,839,600.21 | 3,097,200,304.98 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 997,796,400.21 | 867,207,304.98 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 997,796,400.21 | 867,207,304.98 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 997,796,400.21 | 867,207,304.98 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 855,200,000.00 | 855,200,000.00 |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 142,596,400.21 | 12,007,304.98 |
| 120009 | Бусад орлого | | 549,127.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,158,043,200.00 | 2,229,993,000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,157,993,200.00 | 2,229,993,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,157,993,200.00 | 2,229,993,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 50,000.00 | - |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 50,000.00 | - |
| 2 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН | 3,078,279,823.55 | 2,861,442,573.35 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,078,279,823.55 | 2,861,442,573.35 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,016,892,739.99 | 2,830,136,255.00 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 972,163,267.36 | 1,071,810,077.00 |
| 210101 | Үндсэн цалин | 660,833,667.36 | 1,071,610,444.00 |
| 210102 | Нэмэгдэл | 248,895,900.00 | 199,633.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 62,433,700.00 | - |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 106,989,800.00 | 132,742,598.44 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 68,084,300.00 | 106,428,819.04 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,726,400.00 | 7,617,369.24 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,781,100.00 | 5,261,510.16 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,945,300.00 | 1,221,355.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,452,700.00 | 12,213,545.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 94,248,000.00 | 94,248,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 94,248,000.00 | 94,248,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 55,834,763.08 | 71,042,746.62 |
| 210401 | Бичиг хэрэг | 15,458,890.00 | 22,456,880.10 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,791,000.00 | 20,983,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 21,998,665.08 | 25,428,566.52 |
| 210404 | Ном, хэвлэл | 1,586,208.00 | 2,173,400.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 11,870,100.00 | 10,961,500.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 377,400.00 | 816,200.00 |
| 210604 | Урсгал засвар | 11,492,700.00 | 10,145,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 54,977,233.00 | 69,360,418.56 |
| 210702 | Дотоод албан томилолт | 54,977,233.00 | 69,360,418.56 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 682,353,827.00 | 1,205,328,192.00 |

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|--|-----------------------------|--------------------------------|
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 674,575,176.00 | 1,204,530,392.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,603,800.00 | 739,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 140,900.00 | 58,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 39,600.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,994,351.00 | - |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 1,038,455,749.55 | 174,642,722.38 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 870,221,736.00 | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,750,000.00 | |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 166,484,013.55 | 174,642,722.38 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 61,387,083.56 | 31,306,318.35 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 52,086,399.00 | 30,700,700.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 9,999,011.00 | 8,646,100.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 20,727,488.00 | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 21,359,900.00 | 22,054,600.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 9,300,684.56 | 605,618.35 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,300,684.56 | 605,618.35 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2) | <u>77,559,776.66</u> | <u>235,757,731.63</u> |
| 225 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН | 46,527,778.00 | 514,748,611.02 |
| 225001 | Үндсэн хөрөнгө худалдсаны гарз | 46,527,778.00 | 514,748,611.02 |
| 4 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225) | (46,527,778.00) | (514,748,611.02) |
| 5 | НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4) | <u>31,031,998.66</u> | <u>(278,990,879.39)</u> |

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

СТ-2А

МӨНГӨН ГҮЙЛГЭЭНИЙ ТАЙЛАН

/Төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|-------------|---|-------------------------|-------------------------|
| | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | | |
| 1 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1) | 3,013,243,200.00 | 3,148,693,000.00 |
| 12 | ТАТВАРЫН БУС ОРЛОГО | 855,200,000.00 | 855,700,000.00 |
| 120 | Нийтлэг татварын бус орлого | 855,200,000.00 | 855,700,000.00 |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 855,200,000.00 | 855,700,000.00 |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 855,200,000.00 | 855,200,000.00 |
| 120009 | Бусад орлого | | 500,000.00 |
| 13 | ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО | 2,158,093,200.00 | 2,355,993,000.00 |
| 1310 | Улсын төвлөрсөн төсвөөс | 2,158,043,200.00 | 2,292,993,000.00 |
| 131001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт | 2,157,993,200.00 | 2,229,993,000.00 |
| 1311 | Нэмэлт санхүүжилтийн орлого | 50,000.00 | 63,000,000.00 |
| 131102 | Төсвийн жилийн явцад УИХ-аас соёрхон баталсан, ЗГ хоорондын гэрээ болон ОУ байгууллагаас авах хөнгөлөлттэй зээл | | 63,000,000.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 50,000.00 | |
| 2 | НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2) | 3,013,243,200.00 | 3,148,693,000.00 |
| 21 | УРСГАЛ ЗАРДАЛ | 3,013,243,200.00 | 3,148,693,000.00 |
| 210 | БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 2,951,856,116.44 | 3,078,278,681.65 |
| 2101 | Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 972,163,267.36 | 1,031,652,682.00 |
| 210101 | Үндсэн цалин | 660,833,667.36 | 702,722,182.00 |
| 210102 | Нэмэгдэл | 248,895,900.00 | 238,840,500.00 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 62,433,700.00 | 90,090,000.00 |
| 2102 | Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 106,989,800.00 | 121,725,900.00 |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 68,084,300.00 | 81,150,600.00 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 9,726,400.00 | 10,143,800.00 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 7,781,100.00 | 8,115,100.00 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 1,945,300.00 | 2,028,800.00 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,452,700.00 | 20,287,600.00 |
| 2103 | Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 94,248,000.00 | 94,248,000.00 |
| 210304 | Байрны түрээс | 94,248,000.00 | 94,248,000.00 |
| 2104 | Хангамж, бараа материалын зардал | 57,919,063.08 | 68,205,558.52 |
| 210401 | Бичиг хэрэг | 16,787,190.00 | 22,131,692.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 16,212,000.00 | 18,212,900.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 21,998,665.08 | 25,428,566.52 |

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | |
|-------------|--|-----------------------|-------------------------|
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,921,208.00 | 2,432,400.00 |
| 2106 | Эд хогшил, урсгал засварын зардал | 15,319,300.00 | 11,000,700.00 |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 769,300.00 | 855,400.00 |
| 210604 | Урсгал засвар | 14,550,000.00 | 10,145,300.00 |
| 2107 | Томилолт, зочны зардал | 56,547,233.00 | 72,007,418.56 |
| 210702 | Дотоод албан томилолт | 56,547,233.00 | 72,007,418.56 |
| 2108 | Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 741,385,627.00 | 1,655,046,422.57 |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 733,606,976.00 | 1,654,248,622.57 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,603,800.00 | 739,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 140,900.00 | 58,500.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 39,600.00 | |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 5,994,351.00 | |
| 2109 | Бараа үйлчилгээний бусад зардал | 907,283,826.00 | 24,392,000.00 |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 905,533,826.00 | |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 1,750,000.00 | 24,392,000.00 |
| 213 | УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 61,387,083.56 | 70,414,318.35 |
| 2132 | Бусад урсгал шилжүүлэг | 52,086,399.00 | 30,700,700.00 |
| 213204 | Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 9,999,011.00 | 8,646,100.00 |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 20,727,488.00 | |
| 213207 | Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 21,359,900.00 | 22,054,600.00 |
| 2133 | Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг | 9,300,684.56 | 605,618.35 |
| 213303 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 9,300,684.56 | 605,618.35 |
| 2135 | Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг | - | 39,108,000.00 |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 39,108,000.00 |
| 3 | ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2) | - | - |
| | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 6 | ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5) | - | - |
| 7 | САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ | - | - |
| 8 | НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7) | - | - |
| 9 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | |
| 10 | Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл | | |

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

СТ-4А

ЦЭВЭР ХӨРӨНГӨ/ӨМЧИЙН ӨӨРЧЛӨЛТИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооний нийт дүн |
|-----|--|---------------------------------|-----------------------|-----------------------|-------------|---|
| C01 | 2017 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл | 304,117,253.38 | | 1,143,914,198.11 | | 1,448,031,451.49 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | | | 0.00 |
| C03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 304,117,253.38 | 0.00 | 643,745,967.57 | 0.00 | 947,863,220.95 |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | | | | | 0.00 |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | | | | | 0.00 |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| C07 | Тайлант үеийн үр дүн | | | 31,031,998.66 | | 31,031,998.66 |
| C08 | 2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 304,117,253.38 | 0.00 | 674,777,966.23 | 0.00 | 978,895,219.61 |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | | | 264,748,457.00 | | 264,748,457.00 |
| D03 | Дахин илэрхийлсэн үлдэгдэл | 304,117,253.38 | 0.00 | 939,526,423.23 | 0.00 | 1,243,643,676.61 |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | | | | | 0.00 |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | | | | | 0.00 |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | | | | | 0.00 |
| D08 | Тайлант үеийн үр дүн | | | -278,441,752.39 | | -278,441,752.39 |
| D09 | 2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл | 304,117,253.38 | 0.00 | 661,084,670.84 | 0.00 | 965,201,924.22 |

ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

/ төгрөгөөр /

| Үзүүлэлт | Төлөвлөгөө | Гүйцэтгэл | Зөрүү | Хувь |
|--|------------------|------------------|--------------|--------|
| Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл | | | | |
| НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН | 3,085,193,000.00 | 3,084,587,381.65 | (605,618.35) | 99.98 |
| УРСГАЛ ЗАРДАЛ | 3,085,193,000.00 | 3,084,587,381.65 | (605,618.35) | 99.98 |
| БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ | 3,054,492,300.00 | 3,053,886,681.65 | (605,618.35) | 99.98 |
| Цалин хөлс болон нэмэгдэл урамшил | 1,031,654,500.00 | 1,031,652,682.00 | (1,818.00) | 100.00 |
| Үндсэн цалин | 702,724,000.00 | 702,722,182.00 | (1,818.00) | 100.00 |
| Нэмэгдэл | 238,840,500.00 | 238,840,500.00 | - | 100.00 |
| Унаа хоолны хөнгөлөлт | 90,090,000.00 | 90,090,000.00 | - | 100.00 |
| Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл | 121,725,900.00 | 121,725,900.00 | - | 100.00 |
| Тэтгэврийн даатгал | 81,150,600.00 | 81,150,600.00 | - | 100.00 |
| Тэтгэмжийн даатгал | 10,143,800.00 | 10,143,800.00 | - | 100.00 |
| ҮОМШӨ-ний даатгал | 8,115,100.00 | 8,115,100.00 | - | 100.00 |
| Ажилгүйдлийн даатгал | 2,028,800.00 | 2,028,800.00 | - | 100.00 |
| Эрүүл мэндийн даатгал | 20,287,600.00 | 20,287,600.00 | - | 100.00 |
| Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал | 94,248,000.00 | 94,248,000.00 | - | 100.00 |
| Байрны түрээс | 94,248,000.00 | 94,248,000.00 | - | 100.00 |
| Хангамж, бараа материалын зардал | 68,205,600.00 | 68,205,558.52 | (41.48) | 100.00 |
| Бичиг хэрэг | 22,131,700.00 | 22,131,692.00 | (8.00) | 100.00 |
| Тээвэр, шатахуун | 18,212,900.00 | 18,212,900.00 | - | 100.00 |
| Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 25,428,600.00 | 25,428,566.52 | (33.48) | 100.00 |
| Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 2,432,400.00 | 2,432,400.00 | - | 100.00 |
| Эд хогшил, урсгал засварын зардал | 11,005,000.00 | 11,000,700.00 | (4,300.00) | 99.96 |
| Багаж, техник, хэрэгсэл | 855,400.00 | 855,400.00 | - | 100.00 |
| Урсгал засвар | 10,149,600.00 | 10,145,300.00 | (4,300.00) | 99.96 |
| Томилолт, зочны зардал | 72,007,600.00 | 72,007,418.56 | (181.44) | 100.00 |
| Дотоод албан томилолт | 72,007,600.00 | 72,007,418.56 | (181.44) | 100.00 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж | 1,655,645,700.00 | 1,655,046,422.57 | (599,277.43) | 99.96 |
| Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 1,654,847,900.00 | 1,654,248,622.57 | (599,277.43) | 99.96 |
| Даатгалын үйлчилгээ | 739,300.00 | 739,300.00 | - | 100.00 |
| Тээврийн хэрэгслийн татвар | 58,500.00 | 58,500.00 | - | 100.00 |
| УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ | 30,700,700.00 | 30,700,700.00 | - | 100.00 |
| Бусад урсгал шилжүүлэг | 30,700,700.00 | 30,700,700.00 | - | 100.00 |
| Ажил олгогчоос олгох бусад тэтгэмж, урамшуулал | 8,646,100.00 | 8,646,100.00 | - | 100.00 |

Уул уурхай, хүнд үйлдвэрийн яамны 2018 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

| | | | | |
|---|------------------|------------------|--------------|--------|
| Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж | 22,054,600.00 | 22,054,600.00 | - | 100.00 |
| ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР | 3,085,193,000.00 | 3,084,587,381.65 | (605,618.35) | 99.98 |
| УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ | 2,229,993,000.00 | 2,229,387,381.65 | (605,618.35) | 99.97 |
| Улсын төсвөөс санхүүжих | 2,229,993,000.00 | 2,229,387,381.65 | (605,618.35) | 99.97 |
| ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС | 855,200,000.00 | 855,200,000.00 | - | 100.00 |
| Үндсэн үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 52,588,500.00 | 52,588,500.00 | - | 100.00 |
| Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 802,611,500.00 | 802,611,500.00 | - | 100.00 |
| ОРОН ТООНЫ МЭДЭЭЛЭЛ | 78.00 | 78.00 | - | 100.00 |
| Төрийн захиргааны албан хаагч (ТЗ) | 73.00 | 73.00 | - | 100.00 |
| Төрийн үйлчилгээний бусад албан хаагч (ТҮ) | 3.00 | 3.00 | - | 100.00 |
| Улс төрийн албан хаагч (УТ) | 2.00 | 2.00 | - | 100.00 |

Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

| | | | | |
|--------------------------------|--|---------------------|------------------------------------|-----------------------------|
| Огноо: | 2018 он | Аудитын нэр: | Санхүүгийн тайлангийн аудит | САГ-2019/298/СТА-ТШЗ |
| Шалгагдсан байгууллагын | Уул уурхай, хүнд үйлдвэрийн яам | | мянган төгрөгөөр | |

| № | Алдаа, зөрчлийн товч утга | Мөнгөн дүн | Аудитын байгууллага ас гаргасан шийдэл | Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны | |
|------------|--|--|--|---|------------------------|
| | | | | Албан тушаал | Овог нэр |
| А | 1 | 2 | 3 | 4 | 5 |
| 1 | Жилийн санхүүгийн тайланг хуулийн хугацаа хоцроож ирүүлсэн. | ТЭЗ-ийн нэгтгэсэн санхүүгийн тайлангийн аудитаар хариуцлага тооцуулах албан шаардлага хүргүүлнэ. | | Дарга, ахлах нягтлан бодогч | Х.Хэрлэн Т.Цэрэнд улам |
| 2 | Өглөг авлагын журналыг үнэн зөв бүртгээгүй, харилцагч байгууллагуудтай тооцоо нийлсэн акт үйлдээгүй байна. | | Зөвлөмж | | |
| 3 | Насжилт ихтэй авлага үүсгэснийг барагдуулаагүй, барагдуулах тодорхой арга хэмжээ аваагүй. | 40,181.0 | Зөвлөмж | | |
| 4 | Төсвийг зүй зохистой удирдаагүйгээс авлага, өр төлбөр үүсгэсэн. | 6,769.3 | Зөвлөмж | | |
| 5 | Урьдчилж гарсан зардал, үйлчилгээний төлбөрийг шууд зардлаар бүртгэсэн. | 90,835.7 | Зөвлөмж | | |
| 6 | Улс төрийн албан хаагчид "Төрийн алба хаасан хугацааны нэмэгдэл" бодож олгосон. | 6,569.1 | Албан шаардлага | | |
| 7 | Зардлыг бүлэг хооронд гүйлгэн зарцуулж, гүйцэтгэлийг бодитой тайлагнаагүй. | 21,834.7 | Албан шаардлага | | |
| 8 | Батлагдсан төсвийг зориулалт бусаар зарцуулсан. | 15,292.1 | Албан шаардлага | | |
| | Анхан шатны баримтын бүрдэл дутуу ажил гүйлгээг бүртгэлд тусгасан. | 11,601.5 | Албан шаардлага | | |
| | Санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээний тайланд зардлын дансдыг бодит гүйцэтгэлд үндэслэн тайлагнаагүй. | 415,057.2 | Зөвлөмж | | |
| 9 | Бараа материалын шинж чанартай ажил гүйцэтгүүлснийг шууд зардлаар бүртгэсэн. | 79,844.8 | Зөвлөмж | | |
| 10 | Нийгмийн даатгалын шимтгэлийн тайланд цалин, илүү дутуу тайлагнасан | 2,234.4 | Зөвлөмж | | |
| Дүн | | 690,219.8 | | | |